

Year 1 Phonics Screening Check

| Information for parents and carers

1-р ангийн Дуудлага зүйн шалгалт

| Эцэг эх, асран хамгаалагчдад
зориулсан мэдээлэл



Дуудлага зүй гэж юу вэ?

Дуудлага зүй бол үсэг болон дуу авианы хоорондын холбоо бөгөөд уншиж сурахад чухал үүрэгтэй. Зарим хүүхдүүд уншиж сурахад бэрхшээлтэй тулгардаг тул ийм хүүхдийг хурдан олж тогтоох нь чухал байдаг. Ингэснээр багш нар тухайн сурагчийн хэрэгцээнд тааруулсан төлөвлөгөө гарган ажиллах боломжтой болдог.

1-р ангийн Дуудлага зүйн шалгалт гэж юу вэ?

1-р ангийн авиа зүйн шалгалт нь улсын хэмжээний богино үнэлгээ бөгөөд багш нарт таны хүүхэд дуудлага зүйн хувьд хэрхэн сайжирч байгааг дүгнэх боломжийг олгодог. Энэхүү шалгалтаар таны хүүхэд өөр өөр үсгийн хослол бүхий англи үсгийг хэрхэн уншиж байгааг ажиглан үнэлгээ хийдэг. Багш таны хүүхэдтэй хамт суун хүүхдээр 40 үгийг чангаар уншуулна. Эдгээр үгсэд бодитоор хэрэглэгддэг 20 үг, ямар нэгэн утга илэрхийлэгдээгүй 20 үг орно. Зохиомол үгс уншуулан шалгаж байгаагийн зорилго нь сурагч тухайн үгийг өмнө нь харж байсан ой санамжнаасаа илүүтэйгээр өөрийн сурсан мэдлэгээ ашиглан үсгийг уншиж чадаж байгаа эсэхийг шалгах явдал юм. Шалгалт нь ихэвчлэн 5-7 минут үргэлжилдэг. Хэрэв ингэж унших нь хүүхдэд хүндрэлтэй байвал багш шалгалтыг зогсоон хянана. Уг шалгалт нь таны хүүхдэд стресс өгөхгүй байхаар зохиогдсон болно.

Энэхүү 1-р ангийн дуудлага зүйн шалгалт нь багш нарыг таны хүүхдийн сурах явцад тохирохуйц төлөвлөгөө гаргахад хэрэгтэй мэдээллээр хангах зорилготой юм. Хүүхэд тус бүрийг багш тусад нь үнэлэх ба 1-р ангийн бүх сурагчийг үнэлнэ.

Дуудлага зүй яагаад чухал вэ?

Англи хэлээр уншиж, бичиж сурахад дуудлага зүйн мэдлэг, ур чадвар зайлшгүй шаардлагатай. Үүний тулд сурагчид тусдаа байгаа үсэг эсвэл өөр өөр үсэгнүүдийн нийлбэрээр илэрхийлэгдсэн дуу авиаг сурч, үсгийг уншихын тулд эдгээр дуу авиаг хооронд нь нэгтгэн унших ур чадварт суралцах хэрэгтэй байдаг. Аливаа текстийг унших хурд, хэмнэл болон текстийг бүрэн ойлгоход хүндрэл үүсгэхгүйн тулд анхлан суралцагч нь үгийн дуудлагыг хурдан, чөлөөтэй хослуулж дуудаж сурах хэрэгтэй байдаг.

1-р ангийн дуудлага зүйн шалгалтын талаар асуух зүйл байвал сургуультай холбогдоно уу.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.